

**1930-ААД ОНД ХЭЛМЭГДСЭН МОНГОЛ ЦЭРГИЙН
НЭГЭН ДАРГЫН ХУВЬ ЗАЯА**

Д. Хоролдамба

Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны Төв Khoroldamba@yahoo.com 99749755.

Өгүүллийн товч утга: 1930-1940-өөд онд БНМАУ-д явагдсан улс төрийн их хэлмэгдүүлэлтэд өртөж, амь насаа алдсан цэргийн олон дарга нарын нэг болох Дорнод 2-р морьт корпусын дарга Д.Цагааны ажил, амьдралын замналыг архивын баримтаар тодруулахыг оролдсонд оршино.

Түлхүүр үг: БНМАУ, улс төрийн их хэлмэгдүүлэлт, 1939-1939 оны улс төрийн хядлага, дивиз, цэргийн дарга, Дорнод II морьт корпус, мөрдөн байцаалт, хилс хэрэг

Одоогоос 70 гаруй жилийн тэртээ Монгол оронд болсон улс төрийн их хэлмэгдүүлэлтэд олон зуун цэргийн дарга өртөж, амь насаа алдсан билээ. Тэдгээрийн нэг нь Дорнод II морьт корпусын дарга Д.Цагаан байлаа.

Доржийн Цагаан 1903 онд Халхын Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошуу, хожмын Богд хан уулын аймгийн Зүүнбүрэн хан уулын хошуу, одоогийн Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Шаамар гэдэг газар төрж, хар багаасаа мал маллан, арьс нэхий элдэж, тариа тарих ажил хийн бусдад зарцлагдаж амьдарч байжээ.

1922 онд Алтанбулагт цэргийн албанаа татагдан, улмаар Улаанбаатар хот, Ховд, Завхан зэрэг аймагт жагсаал, хороон даргаар ажиллажээ. Д. Цагаан 1932 оны эхээр БНМАУ-ын Хувьсгалт Цэргийн Зөвлөлийн 2 тоот тушаалаар Завханы 8-р хороон даргаар томилогдон баруун аймагт ажиллаж байх үед 1932 оны дөрөвдүгээр сарын 10-нд Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хялганатын хүрээний орчмоос лам хар нийлсэн цөөн тооны хүмүүс зэвсэгт бослого үүсгэж "Элстийн хамтралыг сүйтгэн"¹ хүрээ нь тэлсээр баруун аймгуудыг хамарчээ. Улмаар олныг хамарсан самуун болон даамжирч, зэвсэглэн хүн алж, хоршоо дэлгүүр, сургууль, соёлын газрыг ч ялгалгүй талж сүйтгэх болжээ.

Нөхцөл байдал ийнхүү хурцадсан учраас БНМАУ-ын УБХ-ын Тэргүүлэгчид, Засгийн Газрын Эрхлэх Товчооны гишүүдийн хамтарсан Онц хурлаас Хөвсгөлд гарсан лам нарын эсэргүү бослогын тухай Дотоодыг Хамгаалах Газрын дарга Намсрайн

¹ Д. Цэрэнбалжир. 1932 оны зэвсэгт бослого. УБ., 1990. х-20.

IV ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

илтгэлийг хэлэлцэж "...эсэргүү бүлгэмийн хөдөлгөөнийг өргөтгөн газар авахуулахгүйгээр дарж устгах, олон түмэнд бослогын хор уршгыг ухуулан таниулах ажлыг зохион байгуулахын тулд... Ж.Лхүмбэ даргатай Тусгай Комиссыг байгуулан Хөвсгөлд"² томилж, холбогдох бусад арга хэмжээ авчээ.

БНМАУ-ын Батлан Хамгаалах Зөвлөл 1932 оны тавдугаар сарын 9-ний өдөр хуралдаж "Хөвсгөл ба Архангай аймгуудын улс төрийн байдлын тухай" асуудал хэлэлцэж, бослого, хөдөлгөөнийг дарах явдлыг шууд удирдах "Батлан Хамгаалах Түр Зөвлөл"-ийг МАХЦ-ийн Улс төрийн газрын дарга Д. Өлзийбатаар толгойлуулан байгуулжээ³.

Хөвсгөл, Архангай зэрэг аймгуудад гарсан бослогыг даруулахаар БНМАУ-ын Хувьсгалт Цэргийн Зөвлөлөөс томилсон ёсоор Улаанбаатар хотын цэргийн ангиудаас Б. Намсрай, Ж. Малж, Д.Ванчиг, А. Содном нарын даргалсан 1000 гаруй хүний бүрэлдэхүүнтэй дотоодын цэргийн дөрвөн отрядыг зохион байгуулж⁴ "Батлан Хамгаалах Түр Зөвлөл"-ийн дарга Д. Өлзийбатын ерөнхий удирдын дор илгээсэн байна. Мөн орон нутгийн нам, эвлэл, төр захиргааны байгууллагууд энэ ажиллагаанд ихээхэн үүрэг гүйцэтгэжээ.

Бослого дарахад дотоодын цэргээс гадна гадаадын цэрэг, техникийн тусламж авсан мэдээ буй. Тухайлбал Тува улсаас томилогдож ирсэн морьт суман болон Зөвлөлт Холбоот Улсаас цэргийн нисэх хүчний отряд оролцсон бөгөөд⁵ Е.Н.Исаков, Юшкиевич зэрэг Орос сургагчид зааж, зөвлөх эрх, үүрэгтэй оролцсон байна⁶.

Хөвсгөл, Завхан, Алтай, Архангай, Өвөрхангай зэрэг аймагт голлон өрнөсөн бослогыг дарах байлдааны ажиллагаанд бүрэн бус тооцоогоор тавдугаар сараас аравдугаар сар хүртэлх таван сарын хугацаанд 100 гаруй цэрэг, дарга амь үрэгдсэн бол босогчдоос 1900 гаруй хүн алагдаж, 500 гаруй хүн шархтжээ. Мөн 2800 хүн баривчлагдснаас 670 гаруйг нь буудан алж, 550-иад хүнийг суллан явуулж, бусдыг нь шүүхээс янз бүрийн хугацаагаар хорьж шийтгэжээ⁷.

Ийнхүү БНМАУ-ын төр, засгийн эрх баригч МАХН-ын дотор "Зүүнтэн" хэмээн нэрлэгдсэн намын зүүн жигүүрийнхний алдаатай бодлогын хор уршгаар олон түмний

² МУУТАрхив. Ф.1. Д.2. ХН. 459. х-35.

³ БХТАрхив. Ф-1, Д-3, ХН-220, х-3.

⁴ Монгол цэргийн түүхийн товчоон. УБ., 1996. х-209.

⁵ БХЯ-ны Цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн фонд дахь ахмад дайчдын дурдатгалууд.

⁶ Монгол цэргийн түүхийн товчоон. УБ., 1996. х-204.

⁷ Монгол цэргийн түүхийн товчоон. УБ., 1996. х-209.

IV ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

эсэргүүцэл, хөдөлгөөн зэвсэгт бослого болтлоо өрнөж, Монгол хүмүүн өвөр зуураа амь өрсөн тэмцэлдсэн нь туйлын харамсалтай бөгөөд уг бослогыг цус урсган дарахад Д. Цагаан тангараг өргөсөн эр цэргийн хувьд оролцохоос өөр аргагүй байсан нь лавтай юм.

Бослогыг дарсны дараа Д. Цагааны захирсан анги аймаг дахь Дотоодыг Хамгаалах хэлтэстэй хамтран бослогын явцад сүйтгэгдсэн захиргаа, сургууль, худалдаа, аж ахуйн байгууллагуудыг сэргээн, үйл ажиллагааг нь хэвийн болгох, бослогын хор хохирол, нам, засгийн бодлогын тухай яриа, таниулга хийж Зүүнтний алдаа завхралыг буруушаан, улс орныг хөгжүүлэх “Шинэ эргэлтийн бодлого”-ыг мөн чанарыг ард олонд тайлбарлан таниулах зэрэг ажилд оролцжээ.

Дараа нь Д. Цагаан 1932-1935 онд ЗХУ-д Фрунзийн нэрэмжит Цэргийн Академид суралцаад эх орондоо иржээ. Тэрбээр орос, хятад хэлэнд сайтар суралцаж цэрэг, батлан хамгаалахын онолын өндөр мэдлэг эзэмшсэний хувьд 1935 оны наймдугаар сараас 1-р дивизийн штабын дарга, 1937 оны нэгдүгээр сараас Баянтүмэн дэх 5-р дивизийн штабын дарга, 1937 оны зургадугаар сараас Тамсагын 6-р дивизийн штабын дарга, даргаар ажиллажээ. Мөн хилийн мөргөлдөөнийг дарахад оролцож цусан гавьяаны нэгдүгээр зэргийн одон, сэлэм, байлдааны дурангаар хоёр удаа шагнагдсан⁸ нь түүний ажлын хариуцлага, чадварыг төр, засгаас зохих ёсоор үнэлснийх юм.

1937 оны аравдугаар сарын 25-нд ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжин, маршал Х. Чойбалсангийн 208 тоот тушаалаар Дорнод II морьт Корпусын даргын хариуцлагатай албанд томилогдож, дивиз командлан захирагч цол олгож, МАХН-ын Төв хорооны 3-р Бүгд Хурлын гишүүдээс орон гарсан 19 гишүүний нэгээр сонгогджээ⁹.

Ийнхүү цэргийн өндөр албанд томилогдсон Д. Цагаан ЗХУ-ын Октябрийн хувьсгалын 20 жилийн ойд оролцох Монголын 10 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийн тэргүүнээр умард хөрш рүү одож И. В. Сталинд бэлэг хүргэж яваад 1938 оны нэгдүгээр сард эх орондоо эргэж ирсэн байна¹⁰.

Д. Цагааныг ажил, албан тушаалд ахиж, корпусын дарга болсон энэ үед Монголын дотоодод улс төрийн их хэлмэгдүүлэлт өрнөн төрийн их хядлага болтлоо даамжирч, гадаадаас Японы түрэмгий цэргүүд үе үе манай Дорнод хязгаарын нутагт

⁸ ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-2.

⁹ МАХН-ын Баримтын төв Ф-4, Д-6, ХН-2, х-189.

¹⁰ ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-29

IV ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

өнгөлзөж, Булан дэрс, Адаг дулаан зэрэг газраар цэргийн хүчээр хил зөрчин Халх голын дайны аюул хаяанд ирээд байлаа.

1938 оны зургаа, есдүгээр сард ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжин, маршал Х. Чойбалсан “МАХЦ-ийн шинэ анги, нэгтгэлүүдийг байгуулах тухай” болон “МАХЦ-ийн дайчилгааны төлөвлөгөөг зохиох тухай” тушаалууд гаргаж МАХЦ-ийн бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд чиглэсэн тодорхой алхмуудыг хийжээ.

Японы түрэмгийллийн өмнөөс хамгийн түрүүнд сөрж, дайралтыг няцаах цэргийн томоохон хүч нь Д. Цагааны командласан Дорнод II морьт Корпус байв.

Түүний бүрэлдэхүүнд Тамсагбулагын 6, Матадын 8, Баянтүмэний 5, Байшинтын 7-р морьт дивизүүд орж байсан юм. Тэдгээр дивизүүдээс бүрдсэн томоохон корпусыг эмхлэн зохион байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх, байлдааны бэлэн байдлыг дээшлүүлж, дайны бэлтгэлийг хангахтай холбоотой зохион байгуулалтын асар их ажилд Д. Цагаан удирдах үүрэгтэй оролцсон байна.

Тухайн үед МАХЦ-ийн даргалах бие бүрэлдэхүүн 1937-1939 оны улс төрийн их хядлагад өртөж асар их хохирол хүлээсэн байлаа. Тухайн үеийн 77 генералтай дүйцэхүйц албан тушаалтны 69 нь хилс хэрэгт хэлмэгдэн цаазлагдаж, 761 цэргийн дарга, улс төрийн ажилтан “улс төрийн талаар найдваргүй этгээд” гэгдэн жагсаалаас гарчээ. Ийнхүү баригдаж ял шийтгэгдсэн, цэргийн албанаас халагдсан дарга нар нь МАХЦ-ийн нийт даргалах бие бүрэлдэхүүний 50-иас илүү хувь болж¹¹ орон тооны дутагдалд орсон бөгөөд ийм байдал тус корпуст ч адил байжээ.

Иймээс Д. Цагаан II морьт Корпусын даргалах бие бүрэлдэхүүний дутагдлыг нөхөн бүрдүүлэх арга хэмжээ авчээ. 1938 оны нэгдүгээр сард тус корпусын ажил байдалтай танилцан, шалгах аар ирсэн ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны Орлогч, дэслэгч жанжин (армийн генерал) Г. Дамбад “цэргийн ангиудад дарга нарын орон тоо дутуу байгаа учир нөхөн томилох” зэрэг асуудлаа танилцуулан харилцан ярилцаж шийдвэрлэжээ¹².

Цэрэг эх оронч үзэл, бие бялдрын хүмүүжил, биеэ авч явах байдал, цэрэг захирах арга барил, царай зүс, мэдлэг боловсролоороо тухайн үеийн цэргийн хүрээнийхэндээ ихэд хүндлэгдсэн дарга Д. Цагааныг Улаанбаатар хотод бүх дивизийн

¹¹ Хорьдугаар зууны Монгол цэрэг. УБ., 2001, х-43.

¹² ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-56.

IV ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

дарга нарын семинарт ирээд гурав хонож байхад нь 1938 оны арваннэгдүгээр сарын 27-ны өдөр ДЯЯ-ны орлогч сайд Н. Насантогтохын батласан дугааргүй ордероор ДЯЯ-ны ажилтан Баясгалан, Батсүх нар улс төрийн хэрэгт дайчлан баривчилжээ¹³.

Үүнээс нэг жилийн өмнө 1937 оны аравдугаар сарын 18-наас 21-ний өдрүүдэд БНМАУ-д өрнөсөн улс төрийн их хядлагыг эхлүүлсэн шүүх хурал Улсын төв театрт болоход Д. Цагаан төлөөлөгчөөр суулцаж байсан бол энэ удаа хилс хэлмэгдлийн ээлжит золиос болжээ.

1938 онд “ам бүл 7, эх Сэрээтэр 70 гаруй настай, эхнэр Цэнд-Аюуш 32 настай, хүүхэн Замбага 11 настай, хүү Бөндөөхүү 9 настай, дүү Дондог 29 настай. Хөрөнгө чинээ үгүй хэмээн ДЯЯ-нд өгсөн мэдүүлэгтээ өгүүлсэн буй¹⁴.

Цагааныг байцаасан мөрдөн байцаалтын протоколоос үзвэл хилс хэрэгт баригдсан хойноо шударга үнэний төлөө хатан зориг гарган тэмцсээр байжээ. 1939 оны наймдугаар сарын 8-ны өдөр мөрдөн байцаагчаас “Таны бие хувьсгалын эсэргүү, Японы тагнуулын байгууллагад оролцож явсан тухайг хөдөлбөргүй гэрчилсэн тодорхой баримтууд мөрдөн байцаалт буй бөгөөд хичнээн нуухыг оролдовч ашиггүй. Иймд өөрийн урвах ажил явууллагын тухай үнэнээ мэдүүлсүгэй” хэмээн тулган шаардсаны хариуд **“Миний бие эх орноосоо урвасан зүйлгүй, харин ч эх орны төлөө зүтгэж хувьсгалт нам засгаар хүмүүжиж дайсан этгээд нартай тэмцэж явсан ба үүнээс хойшид боловч эх орныхоо төлөө өөрийн амь биеийг хайрлахгүй зүтгэх ба эх орныхоо төлөө өөрийн цусны эцсийн дуслыг барагдтал зүтгэмой”** хэмээн эрс хариулсан байдаг.

Энэ өчгийг байцаагч өчүүхэн ч тоомсорлосонгүй, тоомжиргүй хандан “Ухуулах номлох яриагаа зогсоосугай. Мөрдөн байцаалтын газар эсэргүү ажил явууллага нь чинь тодорхой илэрсэн тул үнэнээ мэдүүлсүгэй” гэж тулгахад “миний бие хувьсгалтай тэрслэх ажлыг ер хийгээгүй, үнэн учраа хуулийн өмнө мэдүүлж баймой”¹⁵ гэсэн няцаалт өгч урвасан эсэргүү ажил хийгээгүй ба хуулийн өмнө худал хэлж чадахгүй амой” хэмээн байцаагчийн хууль бусаар хилс хэрэгт холбогдуулан гүтгэж, хөтлөн байцаах гэсэн явуургүй оролдлогод эрс няцаалт өгч, өөрийн ариун нэр төрийг хамгаалсаар байсан баримт ТЕГ-ын Тусгай архивт хадгалагдаж байна.

¹³ ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-10.

¹⁴ ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-2.

¹⁵ ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-8.

IV ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

Тэрээр хат суусан эр цэргийн ёсоор хатуу бэрх тамлалуудыг олон хоног тэсвэрлэн ямарч хэрэг хүлээхгүй тэмцсээр байжээ. Д. Цагааныг мөрдөн байцаасан протоколд **“20 гаруй хоногын турш нойргүй жижүүрлэн байцаах, 10 гаруй хоног кастерт хорих зэрэг хатуу ширүүнээр тулган байцаасан учраас миний бие цааш тэсвэрлэж чадахгүй эсэргүү болж огт худлаар хэрэг хүлээсэн нь хөдөлбөргүй үнэн”**¹⁶ гэжээ. Үнэхээр ч түүний мөрдөн байцаалтын хэргийг сайтар судлахад гарын үсгээ урьд өмнөхөөс тэс өөрөөр зурсан нь анзаарагддаг билээ, Харандаагаа протокол бичсэн цаасан дээр дөнгөж хүргэж салгалсан хөдөлгөөнтэй гараар арай ядан зурсан мэт ажиглагддаг нь мөрдөн байцаалтын хүнд хэцүү залхаалт, зодуурын улмаас ядарч тамирдсан үедээ зурсан гарын үсэг болох нь үзтэл илэрхий.

1938 оны арваннэгдүгээр сарын 27-ны өдөр Д. Цагаан “Миний бие урьд хувьсгалын эсэргүү байгууллагад оролцож явсан хэмээн огт худал мэдүүлсэн бөгөөд эдгээр мэдүүлгийг гаргахын урьд байцаагчид ба сургагчид өөрийн биеийг холбогдолгүй болохыг хэлсэн авч миний үнэнийг сонсохыг хүссэнгүй харин ч байцаалтыг явуулахдаа улам хавчилт ихтэй ба зодож жанчих зэргээр байцаасан болой. Тийм хавчилтын доор миний бие ийнхүү мэдүүлэг гаргасан бөгөөд хэрэв одоо мөрдөн байцаагчаас намайг үл итгэх буюу дахин хавчих ахул урьдах мэдүүлгүүдээ дахин батлах болмуй... Дахин хэлье. Юу хэмээвээс миний бие хувьсгалын эсэргүү ажлыг хийж явсан удаагүй” хэмээн мэдүүлжээ¹⁷.

Гэвч удалгүй “Миний бие мөрдөн байцаалтад өөрийн бүх үнэнийг илчлэн мэдүүлмой. 27(1937) оны хоёр сараас эхлэн хувьсгалын эсэргүү гишүүн болсон бөгөөд анх 5-р дивизийн дарга Лувсангаар элсэгдэн эсэргүү байгууллагад орсон... Лувсангаас манай улсад хувьсгалын эсэргүү байгууллага буй бөгөөд энэхүү байгууллагыг Дэмид ба бусад нам, засгийн удирдагч нар толгойлж буйн дээр бүх дивизийн дарга нар оролцсон гэж хэлсэн”¹⁸ хэмээн аргагүйн эрхэнд хилс хэрэг хүлээжээ.

1939 оны есдүгээр сарын 16-ны өдөр Д. Цагааныг найм дахь удаа байцааж, “Цагаан таны бие өөрийн өдүүлсэн хэргийг мэдүүлж буй боловч уг хэргийн гадаад, дотоодын харилцаа ба зарим бусад зүйлийг илтэд нуун далдалсаар буй тул энэ тухай өчүүхэн төдий нууц далдлахгүйгээр илчилж мэдүүл” гэхэд Цагаан би эл хэрэгт хуулийн

¹⁶ ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-111.

¹⁷ ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-9.

¹⁸ ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-10.

IV ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

газраас нуун далдлаад ял зэмлэлгүй өнгөрсүгэй гэх санаа байхгүй. Зарим зүйлийг орхигдуулснаа одоо шавхаж мэдүүлбээс өнгөрсөн 27 он (1937. Д. Х)-ы наймдугаар сард дэслэгч жанжин Дамбын бие чи Цэнд-Очир лугаа харилцаж байгаад гадаадад эсэргүү ажлын харилцаа барих нэгэн хүн олсугай” гэсэн ёсоор Бямба гэгчийг олж, Манжуурт буй Японы тагнуулын хэрэг эрхлэх Инагүчи гэдэгт нэгэн бичиг хүргүүлэх болсон гэжээ¹⁹.

Үүнээс үзвэл Японд оргож гарсан гэх Бямбыг манай талаас Д. Цагаан нар зохион байгуулж тагнуулын ажлаар гадаадад гаргасан аж. Мөн Дамба “энэхүү бичгийн дотор бичсэн зүйл бол ЗХУ-аас Монгол Улсын харилцаа холбоог салгаж, Японыг түшиглэх хэмээсэн бидний бодлого хэвээр...Иймийн тул одоо бидэнд цэрэг зэвсгийн тусламж түргэн ирүүлэх нь чухал” гэсэн утгатай гэж тайлбарласан гэжээ.

ДЯЯ-ны мөрдөн байцаагчид Д. Цагаанаар “хэлүүлэх” гэсэн бас нэг зүйл нь Оросын Октябрийн хувьсгалын өдрийг тохиолдуулан зэвсэгт бослого гаргах гэж завдаж байсан гэх зохиомол хэрэг бөгөөд есдүгээр сарын 20-ны өдөр Д. Цагааныг ес дэх удаа байцаахдаа энэ тухай хэрэг хүлээлгэж “чадсан” байна. Мөрдөн байцаагч “Цагаан чиний бие хувьсгалын эсэргүү зэвсэгт бослогыг чухам хэзээ, хэрхэн гаргахаар ямар, ямар бэлтгэл, төлөвлөгөөнүүдийг хийж байснаа тодорхойгоор мэдүүл!” хэмээн гүтгэлэгийн чанартай асуулт тавьжээ.

Д. Цагаан “...өөрийн эсэргүү байгууллагын гол зорилгоо биелүүлэх явдал нь гагцхүү зэвсэгт эсэргүү бослого гаргаж гүйцэтгэхээр нэгэнт шийдвэрлэн... Октябрийн баярыг тохиолдуулан гаргахаар төлөвлөж байсан боловч... Октябрийн баяр болж уул бослогоо хэрхэн гаргахаа шийдвэрлэж чадалгүй Дамбын ирэхийг хүлээж гайхсаар өнгөрсөн болохыг хуулийн өмнө батлан мэдүүлмүй”²⁰ гэж хариулсан байна.

1939 оны арваннэгдүгээр сарын 21-ний өдөр Д. Цагаанаас 12 дахь байцаалт авч, “Танай хувьсгалын эсэргүү байгууллагын улс төрийн зорилго нь юу байсан буй, тодорхойгоор мэдүүлсүгэй” гэж шаарджээ. Тэрбээр хариулахдаа “Манай хувьсгалын эсэргүү Японы тагнуулын байгууллагын улс төрийн зорилго нь Зөвлөлт Засагт СССР улс ба Монгол Улс хоёрын хоорондох ах, дүүгийн харилцаа холбоог таслан салгаж МАХН засгийг эзэрхэг түрэмгий Япон улсын тусламжтайгаар өөрчлөн устгаж, хөрөнгөтний харгис хаант засгийг тогтоон байгуулах зорилготой бөгөөд хорлон сүйтгэх

¹⁹ ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-84.

²⁰ ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-92.

IV ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

хор саад учруулах ба эсэргүү хүчнээ өргөтгөн зузаатгахын тулд хань гишүүдийг олноор элсүүлэх ажлуудыг хийж байсан”²¹ гэхчилэн хариулжээ.

1939 оны арванхоёрдугаар сарын 22-ны өдөр Д. Цагаанаас 14 дэх удаагийн байцаалт авч, “Чиний бие хувьсгалын эсэргүү хэргийн тухай үүний урьд удаа дараа тодорхойлсон мэдүүлгүүдээ батлана биз” гэхэд Цагаан миний бие хувьсгалын эсэргүү хэргийн тухай үүний урьд удаа дараа тодорхойлсон мэдүүлгүүдээ цөмийг батлана”²² хэмээн хилс хэрэг хүлээлгэснээр мөрдөн байцаалтын ажиллагаа өндөрлөсөн байна.

Ийнхүү Д. Цагаан хувьсгалын эсэргүү хилс хэргийг хүлээхэд удаан хугацааны турш туйлын харгис хэрцгий эрүү шүүлт, мөрдөн байцаалтын явцад бие махбодоор аргагүй ядарч, ихэд сульдан, сэтгэл санааны хүнд цохилтод орсон явдал ихээхэн нөлөөлсөн бөгөөд нөгөө талаар хилс хэрэг хүлээн амь гуйх ахул ар гэр, нялх хүүхдүүдээ үүрд “эсэргүүний ар гэр” гэгдэн нийгэмд гадуурхагдан хоцрох аюулаас сэргийлэн хамгаалах гэсэн эр нөхөр, эцэг хүний нинжин сэтгэлээр ар гэрийнхэндээ санаа тавьж байсантай холбоотой юм.

Тэрбээр До яамны шорон хэмээх тамд бие, сэтгэлээрээ тарчилж байхдаа эцсийн мөч хүртэл ар гэр, хоёр нялх хүүхдээ өрөвдөн санаа зовж “...ядуу хоосон би улсад хор санасан зүйлгүй юм даа. Худал хэрэг их хүлээсэн боловч хянаж өршөөл олдох магадгүй. Та болон өөрийн сэтгэлийг түр боловч хуурч суумой. Энэ явдал үнэн шүү. Миний хоёр хүүхдийн аз мэдэх хэрэг буй заа”²³ гэсэн горьдлогоо захидалдаа бичиж байсан ч цаазлагдаж, эхнэр Цэнд-Аюуш, охин Замбага, хүү Бөндөөхүү нар нь эсэргүүний гэр бүл гэгдэн гадуурхагдан үүрд өнчирч хоцорчээ.

• Тухайн үед “До” яамны шоронд хоригдон мөрдөгдөж байсан Мэндийн Лувсандорж дурсамждаа газар доорхи харанхуй нүхэнд хоригдож байхад түүний “хана, хаалган дээр хадаас, модоор сийлж бичсэн янз бүрийн бичээс их байлаа. Дорнод Корпусын дарга Цагаан хилс хэрэгт алтан амиа алдлаа” гэсэн бичээсийг би тод санаж байна. Хоригдлуудын ярианаас Цагаан энд байгаагүй Харин Жуковын тусгай хэлтэст байцаагдаж, хэдэн давхар мушгисан гуперээр зодуулж, тамлуулж байсан гэж дуулсан. Тэр Жуковын шорон гэдэг нь Амгалан хавьд л байсан боловуу. ДЯЯ-ны шоронд байсан

²¹ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-108.

²²ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741, х-115.

²³Д. Хоролдамба. Дорнод корпусын дарга Доржийн Цагааныг хэлмэгдүүлсэн нь. Зууны мэдээ.2009.12.10№288(3360),11-р нүүрт.

IV ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

хүмүүсийн бараг ихэнхи нь тийшээ очсон юм гэжээ²⁴. Цэндийн Дамдинсүрэн абугай: Корпусын дарга Цагаантай гэрийн цоорхойгоор ярилцахад тэр “би, хэрэг хилс хүлээхгүй байж чадсангүй. Амгалангийн тэнд очиж байцаагдахад тэсэж чадалгүй хэрэг хүлээлээ. Одоо түргэн л буудуулахаа хүлээж байна гэж ярьж байсан”. Түүний нүүр учиргүй их шарх болсон байхыг би үзсэн юм²⁵ гэх зэрэг мэдээ нь ДЯЯ-ны ажилтнуудын хууль бус, хүний ёсноос ангид, онц харгис аргаар хэрэг хүлээлгэж байсныг нотлох ноцтой баримт болж үлджээ.

1939 оны нэгдүгээр сарын 7-ны өдөр БНМАУ-ын Бүх цэргийн Намын Төв Комиссын 1-р хурлаар Д. Цагаан нарын 20 хүнийг ардын дайсан хэмээн “намын улаан хүрээлэнгээс шууд хөөн цэвэрлэсүгэй”²⁶ хэмээн намаас хөөжээ.

Д.Цагааныг хувьсгалын эсэргүү байгууллагын идэвхитэй нэгэн гишүүн, хувьсгалын эсэргүү Японы тагнуулын байгууллагад ажиллаж ирсэн хэмээн 1940 оны хоёрдугаар сарын 7-ны өдөр БНМАУ-ын Шүүх Цаазын Бичгийн тусгай ангийн 43,44,45-р зүйлүүдийг баримтлан ялын дээд хэмжээгээр шийтгэх ял ноогдуулж, хувийн хөрөнгө ба одон тэмдгийг албанаа хураах шийдвэрийг давж заалдах эрхгүйгээр гаргажээ.

БНМАУ-ын АИХ-ын дэргэдэх Цагаатгах Ажлыг эрхлэх Комиссын 1957 оны долдугаар сарын 15-ны өдрийн 1-р тогтоолоор цагаатгасан байна.

Эгэл ардын хүү Д. Цагаан жагсаалын цэргээс бага дарга, дунд, ахлах, дээд дарга хүртэл цэргийн даргын албыг шат дараалан хашсаар Корпусын дарга, байлдагчаас Дивиз командлан захирагч (дэслэгч генерал) болтлоо дэвшин, Халхын голын байлдаан хаяанд тулсан үед Дорнод Корпусын байлдааны бэлтгэлийг хангах ажилд зүтгэсэн цэргийн авьяаслаг дарга байсан бөгөөд ухаан бодол, мэдлэг чадвар нь ид жагссан үедээ И. В. Сталинизмын төрийн харгислал, их хядлагын золиос болсон Монгол цэргийн сор болсон шилдэг хөвгүүдийн нэг байжээ.

²⁴ Кему сэтгүүл. 2002. №1(1). х-43

²⁵ А. Думбурай. Залхаан цээрлүүлэлт. УБ. 1997. х-55

²⁶ Батлан Хамгаалахын Төв Архив. Ф-18, Д-1. х-38.

IV ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

Abstract

Numerous high-ranking military officers and commanders were subjected to political repression surfaced in the 1930 s-1940 s in Mongolia. One of such officers was D. Tsagaan, commander of corps № 2 in Dornod and dedicated his work and life to defense of the country and was repressed and killed at the age of 37.

Ном зүй

1. МУУТАрхив. Ф.1, Д.2, ХН. 459.
2. БХТАрхив. Ф-1, Д-3, ХН-220.
3. БХТАрхив. Ф-18, Д-1, Х-38.
4. Монгол цэргийн түүхийн товчоон. УБ., 1996.
5. БХЯ-ны Цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн фонд (ахмад дайчдын дурдаггал).
6. ТЕГ-ын Тусгай Архив. Ф-4, ХН-Ц-741.
7. БХТАрхив. Ф-1, Д-1, ХН-438.
8. А. Думбурай. Залхаан цээрлүүлэлт. УБ. 1997.
9. МАХН-ын Баримтын төв. Ф-4, Д-6, ХН-2.
8. Д. Цэрэнбалжир. 1932 оны зэвсэгт бослого. УБ., 1990.
9. Хорьдугаар зууны Монгол цэрэг, УБ., 2001,
10. Д. Хоролдамба. Дорнод корпусын дарга Доржийн Цагааныг хэлмэгдүүлсэн нь. Зууны мэдээ. 2009.12.10 №288(3360), 11-р нүүр.
10. Кему сэтгүүл. 2002. №1(1).



Фрунзийн Академийн сонсогч Д.Цагаан эхнэр хүүхдийн хамт

Handwritten Mongolian script, likely a legal document or a record of a court case, written in a cursive style. The text is organized into several columns, with some lines starting with a vertical line, possibly indicating a new section or a specific type of statement. The script is dense and fills most of the page area.

Д.Цагаан шоронд байхдаа ар гэрийнхэндээ бичсэн захидал. 1938 он